

БАТАЛГААНЫ НӨХЦӨЛ

1. Энэхүү баталгаа нь бүтээгдэхүүнийг худалдан авсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд хүчинтэй. Байгууллагын ахуйн бус үйлдвэр, үйлчилгээний зориулалтад 3 сарын баталгаа олгоно.
2. Та Монгол Улсын аль ч аймаг, хотуудад буй манай компаний салбараас бүтээгдэхүүн худалдан авахад баталгаат хуудас олгогдоно.
3. Хэрэв бүтээгдэхүүн дээрх серийн дугаар баларч уншигдахааргүй болсон, эсвэл серийн дугаарт засвар орсон бол баталгаат засварын хуудас хүчингүй болно.
4. Үйлдвэрийн гэмтэл: Цахилгааны хүчдэл унаагүй, холболт буруу биш гэдэг нь засварчины дүгнэлтээр нотлогдсон, үйлдвэрээс ирсэн доголдолд эд ангийг солиж өгөх, огт ажиллагаагүй байгаа тохиолдолд шинэ бүтээгдэхүүнээр солиж өгөх
5. Дараах тохиолдолд баталгаат хугацаа хүчингүй:
 - Хөлдөх, усанд автах, механик гэмтэл, байгалийн давагдашгүй хүчин зүйлд автах
6. Буруу сонголтууд
 - Бүтээгдэхүүн лацнаас задраагүй бүрэн бүтэн тохиолдолд та Баянгол дүүргийн татварын албанд E-barimt бүртгүүлсэн хүний иргэний үнэмлэхний хуулбар, зарлагын баримт, e-barimt-ыг авчирч буцаалт хийснээр манай компаниас бэлэн мөнгөний буцаалт хийх боломжтой
 - Бүтээгдэхүүн үйлдвэрийн гэмтэлгүй ажиллаж байгаа боловч үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжинд бүрэн нийцэхгүй, хэрэглээнд тохирохгүй байгаа тохиолдолд бүтээгдэхүүний 30% алданги тооцож үлдсэн дүнд буцаалт олгоно.

Серийн дугаар	Худалдсан огноо	Баталгаа дуусах огноо
/.../../.../..
Техникийн номтой танилцсан хүний нэр, гарын үсэг	Худалдагчийн нэр, Гарын үсэг	Баталгаат тамга

дээр дарж температур зөрүүг тохируулна. + болон – товчийг ашиглан (0.2~2хооронд) тохируулж товч дээр дарж дарснаар эсвэл 15 секунд хүлээж автоматаар хадгалагдана.

АШИГЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

Зай солих: Термостатанд хийсэн 2 ширхэг зайг (Батерей) дунджаар 1 жилийн дотор дахин солино. Термостат дэлгэц дээр тэмдэг гарч ирэнгүүт солих шаардлагатай.

Термостат товчлууруудыг цоожлох: **PRG** товч дээр удаан дарснаар цоожны тохиргоог нээх ба хаана. Хэрвээ “LOC” тэмдэгтэй байвал цоожлогдсон ба **PRG** товч дээр 5 секунд дарж “UNLO” тэмдэг гарж ирсэнээр цоож нээгдэнэ.

Термостатын тохиргоог үйлдвэрийн тохиргоо руу буцаах: Ард тагийг авч зайг аваад урд нүүр дээр товч дээр дарсаар зайг буцаан хийж тагийг таглаж дэлгэц бүтэн асах үед товчийг дарахаа больсноор тохиргоо шинэчлэгдэнэ.

Хүлээн авагчийг гар аргаар ажиллуулах: Термостат ажиллагаагүйгээр төхөөрөмжийг дангаар нь ажиллуулахын тулд хүлээн авагч дээр “MANUAL” товч дээр дарж ногоон гэрэл асаана. Төхөөрөмжийн ажиллагааг “M/A” товчийг ашиглан асааж унтрааж болно. Буцаж термостат ажиллагаа руу шилжихдээ “MANUAL” товч дээр дахин дарж ногоон гэрэл унтарна.

Асаах/унтраах: Хүлээн авагчийн хажууд байрлах O/I ашиглан асааж унтрааж болно.

Анхаарах: Төхөөрөмжийг удаан хугацаагаар ажиллуулахгүй бол хүлээн авагчийг мөн адил ундраах шаардлагатай.

Загвар /ST2402RF/



ТЕХНИКИЙН НОМ

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

ST2402RF загварын электрон термостатыг утасгүйгээр хүссэн өрөөндөө байршуулж Даваа-Баасан, Бямба-Ням гарагуудад тус бүрт өдрийн 6 интервалаар хүссэн температураа тохируулан удирдах боломжтой. Манай орон шиг эрс тэс, хүйтэн цаг ууртай нөхцөлд нарийвчилсан тохиргоотой ажиллагаа нь хэрэглэгчид зардал болон тав тухын хувьд давуу талыг олгодог. Термостат нь утасгүйгээр “Хүлээн авагч”-тай 200 метрийн зайд мэдээлэл солилцдог бөгөөд хүлээн авагчийг төхөөрөмжтэй (Цахилгаан зуух, шалны халдаг кабель, бойлер, автомат хаалт) холбодог. Ингэснээр төхөөрөмжийг техникийн өрөө, грашанд байрлуулсан ч амьдарч буй орчны температураар удирдах боломжийг олгодог.

АНХААРАХ: Техникийн номтой бүрэн танилцах шаардлагатай. Суурилуулах, ажиллуулах зааварчилгааг дагаагүйгээс үйдэлтэй бүтээгдэхүүний эвдрэл, гэмтэл гарах эрсдэлтэй гэдгийг анхаарна уу!

1. тохируулгуудын дагуу мөн адил P6 хүртэл тохируулна. Хэрвээ зарим цагийн интервал дээр тохируулга хийхийг хүсэхгүй бол өмнөх тохируулгатай ижил температур дээр тохируулна уу.
2. 6 интервалаа тохируулчаад **PRG** товч дээр дахин дарвал хоногийн тохиргоо цэс рүү орно. Хэрвээ “1” буюу Даваа гарагийн 6 интервалыг тохируулсан бол одоо бусад 6 өдрийн тохиргоог хийснээр тохиргоо амжилттай хийгдэнэ.
3. Бүх 7 өдрийн тохиргоог хийж дуусаад товч дээр эсвэл 60 секунд дараа автоматаар утгууд хадгалагдана.
4. **PRG** товч дээр дахин дарж тохиргоогоо харж өөрчлөх боломжтой. Уг тохиргоог хийсний дараа байнгын уг тохиргоогоор ажиллана.
5. Үйлдвэрийн тохиргоо (Цаанаас өгөгдсөн тохиргоо):
 P1: 6:00 20°C P2: 8:00 15°C P3: 12:00 15°C
 P4: 14:00 15°C P5: 17:00 21°C P6: 22:00 15°C

Түр температур тохиргоо хийх: Долоо хоногийн програмчлалыг түр зогсоож хүссэн температураараа ажиллуулах боломжтой. + болон – товч дээр дарж температурын утга анивчих үед тохируулах температур дээрээ тавьж товч дээр дарснаар эсвэл 15 секунд хүлээж автоматаар хадгалагдана. Энэ тохиргоо нь дараагийн цагийн интервал дээр эсвэл дахиж товч дээр дартал хүчинтэй хэвийн ажиллана.

Тогтмол темератур тохиргоо хийх: + болон – товч дээр дарж температурын утга анивчих үед товч дээр дарж Тогтмол горимд шилжинэ. + болон – товч дээр дарж тохируулахыг хүссэн температурын утга дээр тавьж товч дээр дарснаар эсвэл 15 секунд хүлээж автоматаар хадгалагдана.

Амралтын горимд шилжүүлэх: + болон – товч дээр дарж температурын утга анивчин тохируулах температур дээр тавиад товч дээр дарж Тогтмол горимд шилжинэ. Үүний дараа товч дээр дарж Амралтын горимд шилжинэ. d:1 гэсэн тэмдэг анивчина. + болон – товч ашиглан d1-с d99 хүртэл хэдэн хоног амралтаар явахаа буюу хэдэн хоногоор дээр тохируулсан температураар ажиллуулахаа сонгон товч дээр дарж дарснаар эсвэл 15 секунд хүлээж автоматаар хадгалагдана. Уг тохиргоо нь тохируулсан хугацаа дуусах үед эсвэл товч дээр дарж идэвхигүй болгоно.

Температур тохируулах нэгж утгыг тохируулах: товч дээр 5 секунд дарж товч дээр дарснаар температур тохиргооны хэсэгт шилжинэ. + болон – товчийг ашиглан (-3.0~+3.0 хооронд, 0.5°C нэгжээр) тохируулж товч дээр дарж дарснаар эсвэл 15 секунд хүлээж автоматаар хадгалагдана.

Ажиллах температур зөрүү тохируулах: товч дээр 5 секунд дарж товч дээр дарснаар температур тохиргооны хэсэгт шилжин дахин товч

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Термостат
1	Програмчлал	7 өдөр, 5/2 өдөр, өдөр бүр, 24 цаг
2	Температур заалт	0°C~40°C
3	Температур тохируулга	5°C~35°C
4	Температур мэдрэгч давтамж	±1°C
5	Цахилгаан тэжээл	2 ширхэг AAA 1.5 Вольт батерей
6	Батерей дуусахад үзүүлэлт	“” тэмдэглэгээ үзүүлнэ
7	Ерөнхий гүйдэл	30uA
8	Хэмжээ	120 x 77 x 28 мм

№	Үзүүлэлт	Хүлээн авагч
1	Цахилгаан тэжээл	230 Вольт, 50 гЦ
2	Утасгүй сүлжээний давтамж	868.35 Мгц
3	Сүлжээ дамжуулах зай	100 метр (Ханагүй орчинд)
4	Цахилгаан зарцуулалт	6 ватт.цаг
5	Хэмжээ	86 x 86 x 26 мм

ТӨХӨӨРӨМЖИЙН БҮТЭЦ

Термостат LCD дэлгэцийн бүтэц:



СУУРИЛУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА


Анхаарах зүйлс:

- Термостат болон хүлээн авагчийг зөвхөн дотор тасалгаанд суурилуулж ашиглана. Гадна орчинд ашиглахыг хориглоно!
- Өндөр чийгтэй орчинд суурилуулахыг хориглоно!
- Термостат, хүлээн авагч нь зөвхөн 1 төхөөрөмжинд холбож ажиллуулах зориулалттай. Давхар холболт хийж ажиллахыг хориглоно.
- Термостат холболтыг хийхээс өмнө төхөөрөмжийн тэжээлийг салгана уу.
- Холболтын схемийн дагуу холболтыг хийх шаардлагатай. Буруу холболт хийснээр термостат гэмтэх эрсдэлтэй.

Хүлээн авагчийг суурилуулах: Хүлээн авагчийн ард талыг доод талын 2 боолтыг авч нээгээд L дээр гал, N дээр нойл цахилгаан тэжээл холбож 1, 2, 3 дээр холболтын схемийн дагуу холболтын хийнэ. Холболтуудыг хамгийн нарийндаа 2x1.5мм утсаар холбож болно. Ард талын хэсэгт утаснуудаа холбосны дараа хананд боолтоор бооно. Термостат болон хүлээн авагчийн хооронд зай хэт хол биш байхыг анхаарна уу.

Термостат ажиллуулах: Дээд талын 2 нүх дээр дарж ард талд техникийн үзүүлэлтэнд заасан зайг (Батерей) хийж ажиллуулна.

Холболтын схем:



Схем 2.

АНХНЫ АШИГЛАЛТЫН ЗААВАР

Хүлээн авагчийг төхөөрөмж болон цахилгаан тэжээлд холбосны дараа төхөөрөмжийг асаана уу.

Хүлээн авагч болон термостатыг холбох: Хүлээн авагч дээр “MANUAL” товч дээр дарж ногоон гэрэл асна. “M/A” товч дээр 5 секунд дарснаар ногоон гэрэл анивчиж эхлэнэ. Ногоон гэрэл анивчсанаар термостаттай холбогдоход бэлэн болно. Термостат дээр болон товчуудыг зэрэг хүлээн авагч дээрх ногоон гэрэл унтартал дарна. Ингэснээр холболт амжилттай хийгдэх бөгөөд цахилгаан тэжээл салсан ч холбоос мартагдахгүй.

Цаг тохируулах: Бодит цагийг тохируулах нь долоо хоногийн тохиргоо хийхэд зайлшгүй шаардлагатай.

- товч дээр 1 удаа дарж “1234567” тэмдэг анивчих үед + болон – товчийг ашиглан тоо дээр тавьж долоо хоногийн гарагийг тохируулна. Жишээ нь: Тухайн өдөр Лхагва гараг бол 3 гэсэн тоо дээр тохируулна.
- товч дээр дарснаар долоо хоног тохиргооноос цагийн тохиргоо руу орно. 0-23 утгын хооронд + болон – товчийг ашиглан тухайн цагийн тохируулна.
- товч дээр дарж минутыг 0-59 утгын хооронд + болон – товчийг ашиглан тохируулж товч дээр дарж эсвэл 10 секунд хүлээснээр автоматаар утгууд хадгалагдана.

ТОХИРГООНЫ ЗААВАРЧИЛГАА

Долоо хоногийн програмийн зааварчилгаа: Нэг өдөрт зургаан цагийн интервалуудад тус бүрт өрөөний температур тохируулах боломжтой.

- PRG** товчийг “1234567” тэмдэг анивчтал удаан дарна уу.
- + болон – товчуудыг ашиглан “12345” эсвэл “67” (5/2 өдрийн тохиргоо), “1234567” (Долоо хоногийн тохиргоо), “1” “2” “3” “4” “5” “6” “7” (Өдөр тус бүрийн тохиргоо) зэргээс сонголтоо хийж тохируулах боломжтой.
- Тохируулах өдрөө сонгочоод **PRG** товч дээр 1 удаа дарснаар P1 цагийн тохиргоо руу орно. + болон – товчийг ашиглан тохиргооны анхны цагийг тохируулна. **PRG** товч дээр дахин дарж + болон – товчийг ашиглан минутыг тохируулна.
- PRG** товч дээр дахин дарснаар температурын утга анивчсанаар + болон -товч ашиглан температур тохируулна. Уг температур нь 3 дугаарт тохируулсан цагаас эхлэн хүчинтэй байх юм.

PRG товч дээр дахин дарснаар P2 цагийн тохиргоог дээрх